

## МОНГОЛ ҮГИЙН ЭНЕРГИ

Л. Чулуунбаатар\*

Хүн төрөлхтөн анх сэтгэн ухаарснаа үгээр илэрхийлж чадах болсон тэр цагт л адгуусан төрөлтөн биш оюун сэтгэхүйт, үг хэл хэмээгч хүчирхэг хэрэглүүрт нэгэн бүлэг амьтан болж төлөвшсөн байна. Хүн төрөлхтний хамгийн чухал харилцааны хэрэглүүр болсон тэр үг хэлэнд ер бусын их энергийн хүч байдгийг сүүлийн үед эрдэмтэд судлан гаргах болсон байна. Тийм болохоор монголчууд “Үгээр хүнийг амьдруулж болно, үгээр хүнийг үхүүлж болно” хэмээн хэлцдэг нь монгол үгэнд асар их хүч оршин байгааг илтгэж буй хэрэг юм. Энэ санааг давхар батлан илтгэх олон зүйр үг буй билээ. “Ерөөлийн үзүүрт тос, хараалын үзүүрт цус”, “Үг сөрвөл хэрүүл, үүл сөрвөл бороо”, “Уурлавал уушиг гэмтэнэ, хүлцэлбэл хэнхдэг тэнийнэ”, “Амны билгээс ашдын билиг” хэмээх зүйр үгнүүд байна. Ерөөл магтаал, шүлэг яруу найраг, уянгын дуу зэрэг нь хүний сэтгэлд сайхнаар нөлөөлж эерэг энергийн орчинг бүрэлдүүлж байдаг байна. Хараал зүхэл, ширүүн үг зэрэг нь хүний сэтгэлийг хямрааж, сөрөг энергийн орчинг бий болгож байдаг. Хэлний дөрвөн гэмд худал үг, хов хэлэх, ширүүн үг, чалчих ордог нь үүний баталгаа юм. Ийм үед хүний тархинд “*black hold*” хэмээх хар хий ялгарч мэдрэлийн эд эсүүдээр тархаж байдаг бөгөөд эцэст нь хүнийг амархан хөгшрүүлэх, салга болгох, ядаргаанд оруулах зэрэг бие махбодийн таагүй байдалд хүргэдэг хийгээд үүнийг инээд устгаж алга болгодгийг хятадын эрдэмтэд нээн гаргажээ. Бурханы шашны тарни бол үгийн хүчний агуу цогцыг агуулсан асар их хүч байдаг тул тарнийг олон дахин унших тутам хүч нь улам их эрчимжиж байдаг байна. Мөргөл үйлдэхэд хамгийн гол нь оюун санаагаа дээд түвшинд төвлөрүүлж итгэл бишрэлээ ундраасан байх ёстой гэнэ. Энерги хуримтлуулдаг оюуны хүчээ шингээсэн зүйлүүдийг зөв ашиглаж сурах шаардлагатай байдаг байна. Үүний тулд дуу авиа, хөгжим, арц хүж, гарын дохио зангаа бүжиг зэргийг ашигладаг. Хүмүүн төрөлхтөн оюун ухаанаараа сэтгэн бодсоноо үг хэл хэмээх хүчирхэг хэрэглүүрийг бий болгон түүгээрээ илэрхийлж харилцан ойлголцож мэдээлэл солилцдог. Мантра хэмээхийн *ман* нь сэтгэл, *тра* нь үг бүтээгч зэмсэг гэсэн самгард хэлний үг бөгөөд сэтгэхүйн зэмсэг гэсэн үг болно. Тэрчлэн тарнийг сэтгэхүйн тасралтгүй дэс дараалсан урсгал гэж тайлбарласан бий. Тарни гэдэг бол зарим туслах хэрэглүүрийн дэмжлэгтэйгээр ухамсар ба сэтгэхүйг нэгэн хэмнэлд оруулан залах хэрэглүүр болсон авианы цогцолбор аж. Тарни нь ганц авиа, цөөхөн үетэй үг, эсвэл олон үетэй үг, бүр бүхэл бүтэн сэдэв ч байдаг аж. Тарнийг бясалгахад тусгай суудал “асана”, уншлага “мантра”, мөн харж сэтгэл оюунаа төвлөрүүлэх дүрс “янтра”, хүний хамгийн их мэдрэхүйн энергитэй эрхтэн болох гарын алганы зөв байрлал, хуруунуудын өвөрмөц үйлдэл чагч “мудр”, нэгэн хэмнэлт дуу аялгуу зэрэг

\* Монгол Улсын Их Сургууль, Монгол Хэл Соёлын Сургууль

таван мэдрэхүйг нэг чиглэлд чиглүүлэх тогтсон журамтай ажээ. Тарнийг “бие, хэл, сэтгэл гурвын хүлээсийг алдруулагч хамаг зовлонг машинд амирлуулагч” увидастай хэмээн эрхэмлэдэг байна. Тарнийг уншихуйд сэтгэхүйн нэгдсэн төвлөрлийг бий болгож гадны нөлөөнд бидний хариулж дадсан сэтгэлийн хөдөлгөөнөөс үүсэх алгасарлаас түргэн ангижруулдаг байна. Тарнийн ухааны ёсоор тарни үйлчлэх нөлөө нь түүний үүсгэж байгаа долгионы давтамжинд бус түүнийг ухааран хүлээн авч буй оюуны чадалд байдаг аж. Тарнийг олон дахин давтан уншвал ухамсарт нөлөөлж оюуны энергийн үйлчлэл үзүүлдэг. 1995 онд Америкийн эрдэмтэд үгэнд энерги дагалдан гарах хүчийг судалжээ. Ингэхэд ямарч үгэнд хөдлөхгүй байсан багажны зүү “ум”-ыг хэлэхэд 36 хэмээр хазаажээ. Энэ нь асар хүчтэй энерги байна гэсэн үг юм. Мөн сайхан цэцгийн нэр, эртний Грекийн томъёо зэргийг хэлэхэд багажны зүү үл ялиг хөдөлж байжээ. Хүний гоц мэдрэхүй бусад сонирхолтой сэдвээр олон ном бичиж, орчуулж бидний оюуны мэлмийг гэгээрүүлж яваа Д. Төмөртоогоо гуай “Тарниар эмчлэхүй” хэмээх сонирхолтой номондоо “Эртний дорно дахины гүн ухаантнууд үгийн язгуур чанар хүчирхэг чадлыг ухааран мэдэрч түүгээр сэтгэхүйн зэмсэг болгон оюуны чадлаа илэрхийлэх улмаар хүчжүүлэх өвөрмөц арга ухааныг бий болгосон нь тарнийн ухаан бололтой” хэмээн дүгнэжээ.<sup>2</sup> Тэгвэл энерги судлаач С.Даваахүү “Энэхүү манийн зургаан үсэг УМ МА НИ БАД МИ ХУМ-ыг Арьяавалын зурхэн тарни гэх бөгөөд эх болсон зургаан зүйлийн хамаг амьтны тусын тулд хэмээдэг болой. “УМ” бол ариун тарнийн үг юм. Уг тарни нь асар их эрчим хүч агуулсан бөгөөд тарнийг уншвал ухамсрын дээд төвшинд орших эрчим хүчтэй холбогдох боломжтой. Тарнийн ухааныг эзэмшин гүн бясалгалд орох, бие, хэл, сэтгэлийг нэгтгэн жолоодох замаар гоц мэдрэхүйн чадварт суралцдаг. Тарнийн зориулалт нь элдэв эмгэг зовиураас урьдчилан сэргийлэх хэрэглүүр болдог” хэмээн бичжээ.<sup>3</sup> Оросын эрдэмтэн Корелин А.Н., “Тайный смысл слогов русского языка” хэмээх номыг 2008 онд хэвлүүлсэн бөгөөд энэ номдоо В.А.Чудиновын судалгаанаас иш татаж “Славянчуудын хэрэглэж байсан 2500 гаруй руни бичгийн уншсан бөгөөд тэр нь үеийн бичиг байсан бөгөөд Европт дахинаа түгэн дархаж, мянган жилийн өмнө Ойрх дорнодод үүссэн хүн төрөлхтөний сэтгэхүйн гажилтын үеэс эхэлж үгийн дотоод утгын хүчийг хүн амын ихэнх нь ойлгохоо байж, бичлэгт хадгалагдан үлдсэн боловч нүдэнд үзэгдэх хөшүүрэг нь, үгийн дуудах холбоо, үгийн энергийн хүч нь алга болж эхэлсэн. Энэ нь цаашдаа дуудлагын нэгдмэл байдал алга болж, бие биенээсээ холдсон үг, хэл аялгуунд хуваагдан үеэр бичдэг Руни бичгээс янз бүрийн цагаан толгой үүсгэхэд хүргэсэн” хэмээн бичсэн буй. Монголчуудын удам болох Хүннү нар 2300 гаруй жилийн өмнө лавтайяа руни бичиг хэрэглэж байсан бөгөөд Умарт Хүннү тэр бичгээ Европ дахинд аваачсан хэмээн үзвэл тэндээс нийт европ тэр дундаа бүх славян үндэстэн руни бичиг авсан байж болох талтай байна. Мөн Хүннүгийн хүчирхэг байсан тэр цагт Бурханы шашныг дундад Азиар дамжуулан авч сэтгэхүйн эрчим хүчийг эзэмшихэд давхар ашиглаж байсан нь үгийн хүчтэй энерги бүхий үеийн руни бичиг хэрэглэж байсантай бас холбоотой байна. Сяньбийн дараа төр улсаа мандуулж явсан Их Нирун ч гэсэн энергийн хүч шингэсэн бичгийг авсан нь монгол үгийн хүч, энергийн зохицолдоог төгс болгосон байна. Монгол үг бол эгшиг гийгүүлэгчийн сөөлжсөн зохицолдоотой үеэр хэлэгддэг бүтэцтэй байдаг. Үүний хамгийн сайн баталгаа бол монгол үсгийн цагаан толгойн эгшгээр амилсан бүтэц юм. Жишээлбэл: Монгол бичгээр хүч хэмээх үгийг “*küchü*”, “*küchi*” хэмээн хоёр янзаар бичдэг. Эхний бичлэг нь аливаа хүч бяраа гаргах зүйлийн тухайд хэрэглэх хувилбар бөгөөд эцсийн үе нь *chü* бөгөөд монгол хүн аливаа хүч гаргах, хүнд юм өргөх зэрэгт *chü* хэмээн хэлдэг. Мөн тэрчлэн морио хурдан явуулахын тулд *chü*: хэмээн давирахад морь хар аяндаа хурдлах бөгөөд энэ нь *chü* гэсэн үгийн хүчтэй тухайн хүний сэтгэлийн хүч нэгдэн нийлж бас цаашлавал морины хүчтэй нэгдээд өөрийн эрхгүй ухасхийхэд хүргэдэг байна. Хоёрдахь бичлэгийн хүч бол аливаа айраг

<sup>2</sup> Д. Төмөртоогоо, “Тарниар эмчлэхүй”, УБ., 2002, х 8

<sup>3</sup> С.Даваахүү, Биоэнерги III, УБ., 2010, х 75-78

тараг мэтийн исэлтийн хүч хэмээхийг заах хэлбэр бөгөөд мөн эцсийн үе нь *chi* бөгөөд энэ тараг айргийн исэлтийн дээд шатанд хүрэхэд *chi* хэмээх авиа гарган шуугин шаагиж байдаг. Тэгээд ч исэлт нь ханасан айргаар л шимийн архи нэрэхээс исээгүй хүч ороогүй айргаар архи огт нэрдэггүй билээ. Гүүний айраг исэлт ханасан уухад бэлэн болсныг нь сайхан чимчигнэсэн айраг хэмээн хэлцэх нь бий. Энэ чимчигнэсэн хэмээх үгийн *chi* бол хүчи хэмээх хувилбарын *chi* бас явж байна гэсэн үг юм. Ер амнаас нь сайхан үг гардаг хүний зан төлөв дөлгөөн түвшин, нийтэч хүн бүхэн түүнд дуртай байдаг. Тийм болохоор “Зан сайтай айлд хүн бүхэн цугладаг, замаг сайтай усанд шувуу бүхэн цугладаг” хэмээн хэлцдэг нь үүний тод баталгаа юм. Тэр сайхан зангийн илрэлийг гагц биеийн хөдөлгөөн, нүүр царайны байдлаар бүрэн төгс илэрхийлж үл чадах бөгөөд үүний ихэнх хувийг үгийн сайхан, ярианы сайхнаар илэрхийлэн гаргадаг байна. Ялангуяа өвгөд үгийг их удаан бодож байж хэлдэг. Тийм болохоор өвгөдийн цээж уужуу хэмээх үг гарсан байж таарна. Нөгөө талаар хүний биеийн 70 хувь нь уснаас бүрэлдэх бөгөөд ус бол аливаа энергийг маш амархан шингээн авдаг байна. Тийм болохоор хүн муу үг хэлэхэд муу үгийн энерги маш амархан бий болж бие махбодыг хямрааж байдаг. Хэрүүл уруултай гэр бүлд өссөн хүүхдийн зан чанар тогтворгүй, муу юманд өртөмтгий, хэл ярианы соёлгүй болж өсдөг. Үүнийг Японы эрдэмтэн Масару Эмото “Хариулт нь усанд бий” гэсэн номдоо баталсан байдаг. Хоёр шилэн саванд цэвэр сайхан ус хийгээд нэг усанд нь долоо хоногийн турш дандаа сайхан үг хэлж, нөгөөхөд нь дандаа муу үг хэлж байсан байна. Сайхан үг хэлж байсан ус нь долоо хоноход огт муудахгүй байсан бөгөөд муу үг хэлж байсан ус нь гурав хоноод үнэр орж муудаж эхэлсэн байна. Дээж авч хөлдөөж үзэхэд сайхан үг хэлж байсан усны талст зөв сайхан гоё цэцгэн бүтэцтэй нөгөөх нь хэлбэр дүрсгүй арзгар болсон байна. Тэгээд Масару Эмото “Шашин болон гүн ухаанаас тэс хөндлөн мэт санагдах ус болон бусад бодисыг өөрчлөх хүч хүний үг бодолд буй гэснийг үл харгалзан, хүний үг, ухамсар оюуны хүч мөсний талстат нөлөөлөн хэлбэржүүлж байгааг хараад ийм олон хүний сэтгэл хөдлөх юм гэж санаагүй” хэмээн дуу алдан бичсэн байдаг.<sup>4</sup> Тийм болохоор 70-80 хувь нь ус агуулагдаж байдаг хүний бие сайхан үг сонсвол энергийн болоод бие махбодыг зөв сайхан бүтцэт эрэмблэгдэж байхад муу үг сонсвол сөрөг энергийн хуримтлал үүсч бие мах бодын болон эсийн эмх цэгцгүй замбараагүй бүтэц бий болж, бие хямарч, бүр цаашилвал өвчний эх суурь болдог байна. Монголчуудын ардын дуу, уртын дуу, бүүвэйн дуу бол сэтгэлийг тайвшруулж эерэг энергийн таатай орчин бүрэлдүүлж байдаг үгийн агуу цогцыг хадгалсан онцгой нэгэн соёлын элемент байдаг. Ботгоо голсон ингийг хуурын аялгуу сонсож тоорын уянгат аялгуугаар аргадсаар байтал нүднээсээ нулимс бөмбөрүүлэн ботгоо авдаг нь үг аялгууны ид шид мөнөөс мөн. Монголын хөгжмийн нэрт зохиолч, төрийн хошой шагналт Н.Жанцанноров “Монголын хөгжмийн таван эгшигтийн онолын асуудалд” хэмээх бүтээлдээ “Тэнгэртэйгээ ухаанаараа харилцдаг монгол хүний уран сайхны сэтгэлгээ чухамдаа орчин зайн асар их хөгжлийг олж, орон зайн урлах хэрэг, үүргийн хувьд цагийн хэмжүүрээс давж хөгжмийн урлагийн бүтээлийн хэлбэрийг бүрэлдүүлж, бүтцийг төгөлдөржүүлдэг. Сэтгэлгээний энэ уламжлал нь үгээр хэлж, дүрс хөдөлгөөнөөр үзүүлдэггүй жинхэнэ сэтгэлийн үг, ая эгшгээр илэрхийлэгддэгийн хувьд хөгжмийн урлагт орон зайн сэтгэлгээ ноёлох байртай байна. Монголын хөгжмийн бусад ард түмнээс ялгагдах хамгийн гол онцлог өвөрмөц шинж нь чухамхүү орон зайн ихээхэн хөгжингүй сэтгэлгээтэй холбоотой гэж үзэх үндэстэй юм... Монгол уртын дуу мөн л монголчуудын орон зайн онцгой мэдрэмж, уран сайхны тод тусгал”<sup>5</sup> хэмээсэн байдаг. Сүм хийдийн хурал номын үг ихэвчлэн магтаалын үгс байх бөгөөд номын ая дан нь сэтгэлд нийцтэй нэгэн хэмийн жигд хэмнэлтэй байдаг. Магтаалын үгийн хүч, ая дангийн таатай хэмнэл хоёр нийлж хүний сэтгэлийн эерэг энергийн хүчийг нэмж бие махбод болоод оюун санаанаас сөрөг энергийг саармагжуулан арилгахад тусалдаг байна.

<sup>4</sup> Масару Эмото, “Хариулт нь усанд бий”, УБ., 2007, х 4

<sup>5</sup> Н.Жанцанноров, “Монголын хөгжмийн таван эгшигтийн онолын асуудалд”, УБ., 2006, х 85-86

Нэгэнт эерэг энергийн давамгайлал бий болсон нөхцөлд бие махбод сэргэлэн цовоо болж, ажлын эрч хүч нэмэгдээд, амьдралын хэмнэл зөв голдрилдоо ордог байна. Ийм болохоор л монголчууд “Үгээр хүнийг үхүүлж болно, үгээр хүнийг амьдруулж болно” хэмээн хэлэлцдэг нь туйлын учир утгатай ажээ. Увидастан Д.Төмөртоогоо “Увидас” номдоо Б.Ринчин багшийн ярьсан яриаг дурдан оруулсан байна. Ринчин гуайд ярьсан хүн “шүд унаснаас хойш ховс хийж чадахаа байсан гээд урьд өмнийн нэг тохиолдлоо ярихдаа хүн мал усгүйдэж их ядраад мөн худаг хүрэхэд бас их хол байсан тул ховсдон тогоонд ус хийж цай чанаад, мөн ховсдон ус гаргаж тэмээнд уулгаад худаг хүртэл дажгүй явж хүрсэн” тухай ярьсан байна. Тэгээд тэр ховсчоос Б.Ринчин багш “Та харь хүнд хийж чадах уу?” хэмээн асуухад “Монгол хэл мэддэг бол чадна” гэсэн нь хүний хэл сонсолтой хамаатайгаар сэтгэлийг захирдаг арга байсан байна. Тэгэхээр монгол хэлээр ховсдол монгол хүндээ үйлчлэх нь багтай байна. Гэтэл тарни, дом шившлэгийн үг аль ч хэлэнд байсан хүн малд үйлчилдэг нь туйлын сонин байна. Ц.Дамдинсүрэн гуйн тэмдэглэн үлдээснээр бол Зүүнхараа зэрэг газарт шившлэгтэй орос эмгэд байсан бөгөөд нэг удаа нэг орос эмгэн холоос шившин азарганы сэлдийн өтийг унагаж эдгээсэн байна. Тийм болохоор хүн өөрийн сэтгэхүйн хүчээр адгуус амьтанд нөлөөлж болдог нь тодорхой байна. Монгол ардын дуунд ийнхүү малын өтийг шившин эдгээдэг арга байсныг Ш.Гадаамба, Х.Сампилдэндэв нарын зохиосон “Монгол ардын аман зохиол” хэмээх номд дурдсан ажээ. Монголд ийм шившлэгийг шүд унаагүй хүн хийдэг домтой гэнэ. Шившигч шүдээ унавал даруй шившлэгээ залуу хүнд зааж өгдөг байсан гэнэ. Харин шившлэг, тарнийн үг нууц байна. Ер нь өт ч биш өвчин зовлон элдэв гачаалд хэрэглэдэг тарни, шившлэгийг нууцалж ирсэн тухай мэдээ олон байдаг байна.<sup>6</sup> Үгээс гадна түүнийг бүрдүүлж байдаг дуу авианд ч бас энерги агуулагдан байдаг байна. Түүнийг бичгээр тэмдэглэх авианы цагаан толгойн үсэгт ч энерги хадгалагдан байдгийг эрдэмтэд нэгэнт ажиг тэмдэглэжээ. Оросын эрдэмтэн А.П.Журавлевийн судалснаар авианы шинж чанар, хүч, хөдөлгөөн гэсэн орон зайн гурван хэмжигдэхүүнээр илэрхийлэгдэж байсан бөгөөд л-н хоорондоо дөт, д-б ойролцоо байрласан, х-гээс б хурдан, н-ээс д хүчтэй, л нь х-гээс илүү таатай зөөлөн сонсогддог нь илт байсан байна. Монгол хэлний а эгшиг цээл, бараа овортой, уудам, бүтэн шинжийг заадаг бол и хэмжээний хувьд хавчиг хэсэг зуур үйлдлийг дам илэрхийлдэг байна. Эр эгшиг нийтдээ хэмжээний хувьд нягт, тойрог том эзэлхүүнийг заадаг бол эм эгшиг хэмжээний хувьд далайц багатай, сийрэг, уйтан шинжийг дам гаргадаг байна.<sup>7</sup> А.П.Журавлев “... Авианы утга нь аль нэг талаар уг авианыхаа физик шинжийг тодорхойлно хэмээгээд...Авиа нь утгатайгаа тохирдог нь илэрхий юм”. Иймээс авианы дуудлага нь тэмдэглэж буй бодит юмныхаа авианы талыг шууд дурсэлдэг гэж бичжээ.<sup>8</sup> Судлаач Г.Доржсүрэн: “Монгол хэлний дуу чимээ дууриасан үгийн дотор эгшиг, гийгүүлэгч сэлгэх ба [ н, с - в - г - р - л ] гийгүүлэгчээр төгсөх нь дуу чимээний өнгийг ялгаруулах чухал үүрэгтэй» гээд [в] - авиа хоёр юм агшин зуур хүчтэй мөргөлдөх [р] - авиа араатан хүрхрэх, юм унах зэрэг утгыг илэрхийлнэ хэмээн тайлжээ.<sup>9</sup> Авиа зүйч Р.Якобсон “... эр эгшиг нь “харанхуй”, эм сул эгшиг нь гэрэлтэй, уужим эгшиг нь “том”, уйтан эгшиг нь “бага” утгыг заана” хэмээн бичсэн байна. Тодорхой авианы сэтгэхүйд үүсгэх дам өнгийг тодорхойлох зорилгоор уг авиаг сонсоод сэтгэлд ямар өнгө буух туршилт явуулж үзэхэд:

- [а] - г цагаан (том агуу, уудам)
- [у] - г улаан (тод, түргэн)
- [о] - г хөх цэнхэр (овортой)
- [э] - г шар болон дагалдах өнгөөр

<sup>6</sup> Д.Төмөртоогоо, Увидас, УБ., 2010, х 99-103

<sup>7</sup> Д.Энхбат, “Хүмүүний зохист нэр”, УБ., 2004, х 114

<sup>8</sup> А.П.Журавлев, Фонетическое значение, ЛГУ. 1974

<sup>9</sup> Г.Доржсүрэн. Монгол хэлний дуу чимээ дуурайсан угийн тухай. ШУА.1969. № 3

## Л. Чулуунбаатар

[и] - г бараан, хүрэн, бор өнгөөр

[ү] - г саарал бүрхэг өнгөөр

[ө] - г ногоон, таатай өнгөөр тодорхойлсон нь сонирхол татаж байна.

Доктор М.Базаррагчаа “Монгол хэлний үгийн гарлыг мөшгөх нь” бүтээлдээ “Монгол хэлний бүх үгийн гарлын утга нь РА - ХА - СА - ТА - гэсэн 4 махбод утгат үед хуралдсан гээд - РА-ХА - Н бүтэх утгатай СА-ХА - эвдрэх утгатай, эдгээрээс авиа сэлгэх байдлаар бусад утга салаалсан. Монгол хэлний эр чанга эгшиг эршүүд шинжийг заадаг бол эм сул эгшиг нь зөөлөн намуун шинжийг илэрхийлдэг аж. Монгол хэлний авиа хийгээд түүний илрүүлэх утга хоёр хэлний дотоод гадаад бүтцийн аль аль талаас үзсэн ч хоорондоо шүтэн барилдсан тогтолцоонд оролцдог”<sup>10</sup> гэсэн нь олон эрдэмтдийн анхаарлыг зүй ёсоор татаж байна. ОХУ-ын эрдэмтэн Б.Шкатовын торсион хэмжигчээр орос хэлний цагаан толгойн үсгүүдийг хэмжихэд ийм гарч байсан байна. Нэмэх тэмдэгтэй үсгүүд баруун эргэлттэй буюу эерэг торсион орныг, хасах тэмдэгтэй үсгүүд зүүн эргэлттэй буюу сөрөг торсион орныг үүсгэж байсан байна.

- 4
- 3 А, Ф
- 2 К, М, Н, П, У, Ю
- 1 Г, Е, И, Л
- 0 Б, Р, Ъ, Щ, Я
- +1 Д, Ц, Ш, Э
- +2 Т, Х, Ы, Ы, Й
- +3 Ё, Ж, З
- +4 В, Ч
- +5 С
- +6 О

Тэгвэл орос үсгийг цагаан толгойгоо болгон зээлж авсан бидний цагаан толгой мөн адил байх нь дамжиггүй бөгөөд харин орос цагаан толгойд байхгүй “ө” үсгийг дүүжингийн аргаар энергийг хэмжиж үзэхэд баруун эргэлттэй буюу эерэг торсион орныг, “ү” үсэг зүүн эргэлттэй буюу сөрөг торсион орныг үүсгэж байгаа нь машин сонин байв. Тийм болохоор “ө” үсэг “о”-той бүтэх орноор ойролцоо учир +6 О-гийн хамт байрлаж, ү болохоор у-тай бүтэх орноор ойролцоо тул -2 У-тай адил байранд байх нь дамжиггүй байна. Гэхдээ эдгээр үсгээс бүрдсэн үг эерэг, сөрөг энергиэ дагаад тийм энергитэй үг болно хэмээн бодмоор байвч *алах, үхэл, хардалт* хэмээх үгийг дүүжингийн аргаар үзэхэд зүүн эргэлттэй буюу сөрөг торсион орныг үүсгэж, *амгалан, амьдрал, хайр* хэмээх үгийг мөн адил үзэхэд баруун эргэлттэй буюу эерэг торсион орныг үүсгэж байгаа нь үг тухайн мөн чанарынхаа энергийг хадгалдаг гэдэг нь баттай байна. Сэтгэлийн эрчим хүчний илрэн гарах хэлбэр нь үг юм. Сансрын эрчим хүчийг сэтгэл зүйн эрчим хүч хэмээн их эрдэмтэн Ю.Н.Рерих нэрлэсэн нь буй. Бүхий л эрчим хүчний дотроос хамгийн эмзэг нарийн нь хүний сэтгэл болно.<sup>11</sup> Бидний сэтгэлийн бодит биелэл нь Монголчууд бидний эх хэл болсон монгол хэл юм. Зөв сайхан энергитэй үгсийг хэрэглэж явбал бидний амьдрал баяр баясгалангаар дүүрэн байх болно.

<sup>10</sup> Монгол хэлний үгийн гарлыг мөшгих нь. I, II. Удиртгал нь Өвөрмонголд 1996 онд хэвлэгдсэн, УБ. 1992. 20 х.х. 401.

<sup>11</sup> С.Даваахүү, Биоэнерги III, УБ., 2010, х 12

**НОМ ЗҮЙ**

1. М.Базаррагчаа, Монгол хэлний үгийн гарлыг мөшгих нь. I, II. Удиртгал нь Өвөрмонголд 1996 онд хэвлэгдсэн, УБ., 1992
2. С.Даваахүү, Биоэнерги III, УБ., 2010
3. Г.Доржсүрэн. Монгол хэлний дуу чимээ дуурайсан угийн тухай. ШУА. УБ., 1969. № 3
4. Н.Жанцанноров, “Монголын хөгжмийн таван эгшигтийн онолын асуудалд”, УБ., 2006
5. А.П.Журавлев, Фонетическое значение, ЛГУ. 1974
6. Корелин А.Н., “Тайный смысл слогов русского языка”, Москва, 2008
7. Масару Эмото, “Хариулт нь усанд бий”, УБ., 2007
8. Д. Төмөртоогоо, “Тарниар эмчлэхүй”, УБ., 2002
9. Д.Төмөртоогоо, Увидас, УБ., 2010
10. Д.Энхбат, “Хүмүүний зохист нэр”, УБ., 2004